



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 СУУРЬ БОЛОВСРОЛ

8  
АНГИ

## НИЙГЭМ СУДЛАЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....



## САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
- Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
- Даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

Дараах тохиолдлуудыг уншаад 1-7 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.



Хичээлийн шинэ жилээр 8а ангийн багш Тулга нь сурагчидтайгаа ярилцаж ангийн даргыг шинээр томилохоор болов. Ангийн сурагч Болормаа нь 7 дугаар ангидаа гаргасан бүх сурагчийн амжилт, шагнал, хариуцлага зэргийг нь харгалзан үзээд ангийн даргыг томилох санал өгсөн. Мөн сурагч Гэрэлээ нь бусдын санал бодлыг үл ойшоодог, өөрийн зорилгыг урьтал болгодог сурагчдыг ангийн даргын санал хураалтаас хасах хэрэгтэй гэсэн санал өгчээ. Гэвч зарим сурагч нь Болормаа, Гэрэлээ хоёртой санал зөрж сурагчдын дунд маргаан үссэн. Хэсэг бүлэг сурагч нь ангийн даргыг зөвхөн багшийн саналаар сонгох хэрэгтэй гэсэн санааг гаргаж бусад сурагчдын оролцоог хязгаарлах санал ч гаргасан. Энэхүү маргаан нь улам ширүүсэж, зарим сурагчийн бусдадаа гаргаж байгаа хандлага нэгнээ доромжлох маягтай болсон. Үүнд ангийн багш Тулга нь запруулга хийж суралцагчид бие биеэ ойлгож, ангийн даргаа сонгох шийдэлд хүрсэн.



Багш Тулга нь ангийнхаа сурагчдадаа “Өндөр хэрэглээнд хэт их ач холбогдол өгснөөр мэдлэг, шударга үнэн, хүнлэг сэтгэл зэргээс илүү эрхэмд үзэх” явдал бий болдог. Тиймээс өндөр хэрэглээнд биш хичээл сурлагадаа анхаарч ажиллаарай гэж хэлжээ.



7-9 дүгээр ангийн сурагчдад хичээлийн шинэ жил эхэлснээс 8 долоо хоногийн дараа Түүх-Нийгмийн ухааны багш нар дараах чиглэлээр мэдээлэл хүргэхээр болов. Үүнд: Кирилл бичигтэй болсон шалтгаан; Цаг уурын өөрчлөлттэй холбоотой ган зудын гамшиг; 20 дугаар зуунд компьютерыг бүтээсэн; Зан заншил, ёс суртахуун

- Маслоугийн хүний хэрэгцээний шатлалын хүндлэл хүлээх хэрэгцээг аль хэсэг нь илэрхийлж байна вэ?
  - Хичээлийн шинэ жилээр 8а ангийн багш Тулга нь сурагчидтайгаа ярилцаж ангийн даргыг шинээр томилохоор болов.
  - Сурагч Болормаа нь 7 дугаар ангидаа гаргасан бүх сурагчийн амжилт, шагнал, хариуцлага зэргийг нь харгалзан үзээд ангийн даргыг томилох санал өгсөн.
  - Мөн сурагч Гэрэлээ нь бусдын санал бодлыг үл ойшоодог, өөрийн зорилгыг л урьтал болгодог сурагчдыг ангийн даргын санал хураалтаас хасах хэрэгтэй гэсэн санал өгчээ.
  - Үүнд ангийн багш Тулга нь запруулга хийж суралцагчид бие биеэ ойлгож, ангийн даргаа сонгох шийдэлд хүрсэн.
- Зөрчилдөөнийг шийдвэрлэх хоёрдугаар алхмыг аль хэсэг нь илэрхийлж байна вэ?
  - Хэсэг бүлэг сурагч нь ангийн даргыг зөвхөн багшийн саналаар сонгох хэрэгтэй гэсэн санааг гаргаж бусад сурагчийн оролцоог хязгаарлах санал ч гаргасан.
  - Энэхүү маргаан нь улам ширүүсэж, зарим сурагчийн бусдадаа гаргаж байгаа хандлага нэгнээ доромжлох маягтай болсон.
  - Мөн сурагч Гэрэлээ нь бусдын санал бодлыг үл ойшоодог, өөрийн зорилгыг л урьтал болгодог сурагчдыг ангийн даргын санал хураалтаас хасах хэрэгтэй гэсэн санал өгчээ.
  - Үүнд ангийн багш Тулга нь запруулга хийж суралцагчид бие биеэ ойлгож, ангийн даргаа сонгох шийдэлд хүрсэн.

3. Зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагуудын тухай Томас-Киллманы загварын сөргөлдөх гэсэн ойлголтыг илэрхийлж байгаа хэсгийг олоорой.

  - Хэсэг бүлэг сурагч нь ангийн даргыг зөвхөн багшийн саналаар сонгох хэрэгтэй гэсэн санааг гаргаж бусад сурагчийн оролцоог хязгаарлах санал ч гаргасан.
  - Энэхүү маргаан нь улам ширүүсэж, зарим сурагчийн бусдадаа гаргаж байгаа хандлага нэгнээ доромжлох маягтай болсон.
  - Мөн сурагч Гэрэлээ нь бусдын санал бодлыг үл ойшоодог, өөрийн зорилгыг л урьтал болгодог сурагчдыг ангийн даргын санал хураалтаас хасах хэрэгтэй гэсэн санал өгчээ.
  - Үүнд ангийн багш Тулга нь запруулга хийж суралцагчид бие биеэ ойлгож, ангийн даргаа сонгох шийдэлд хүрсэн.

4. Соёлын хожимдол гэсэн ойлголтыг аль хэсэг нь илэрхийлж байна вэ?

  - 7-9 дүгээр ангийн сурагчдад хичээлийн шинэ жил эхэлснээс 8 долоо хоногийн дараа Түүх-Нийгмийн ухааны багш нар дараах чиглэлээр мэдээлэл хүргэхээр болов.
  - Багш Тулга нь ангийнхaa сурагчиддаа “Өндөр хэрэглээнд хэт их ач холбогдол өгснөөр мэдлэг, шударга үнэн, хүнлэг сэтгэл зэргээс илүү эрхэмд үзэх” явдал бий болдог.
  - Үүнд: Кирилл бичигтэй болсон шалтгаан; Цаг уурын өөрчлөлттэй холбоотой ган зудын гамшиг; 20 дугаар зуунд компьютерыг бүтээсэн; Зан заншил, ёс суртахуун
  - Цаг уурын өөрчлөлттэй холбоотой ган зудын гамшиг; Зан заншил, ёс суртахуун

5. Соёлуудын харилцан нөлөөлөл, нэвчилтийн үйл явцад аль хэсэг нь хамаарч байна вэ?

  - Цаг уурын өөрчлөлттэй холбоотой ган зудын гамшиг
  - Кирилл бичигтэй болсон шалтгаан
  - 20 дугаар зуунд компьютерыг бүтээсэн
  - Зан заншил, ёс суртахуун

6. Оюуны соёлыг аль хэсэг нь бүрэн илэрхийлж байна вэ?

  - Кирилл бичигтэй болсон шалтгаан
  - Цаг уурын өөрчлөлттэй холбоотой ган зудын гамшиг, кирилл бичигтэй болсон шалтгаан
  - 20 дугаар зуунд компьютерыг бүтээсэн, зан заншил, ёс суртахуун
  - Зан заншил, ёс суртахуун, кирилл бичигтэй болсон шалтгаан

7. Соёлын өөрчлөлтүүд зарим тохиолдолд зөрчлийг дагуулдаг уу?

  - Соёлын өөрчлөлт нь соёлын харилцан нөлөөлөл болон нэвчилтээр өөрчлөгддөг тул зөрчил дагуулдаггүй.
  - “Өндөр хэрэглээнд хэт их ач холбогдол өгснөөр шударга үнэнээс эрхэмд үзэх” явдал гардаг тул зөрчил дагуулдаг.
  - Хүмүүсийн амьдралын хэв маяг, соёлын өөрчлөлтөд байгалийн хүчин зүйлс нөлөөлдөг тул зөрчил гардаггүй.
  - Шинэ бүтээл, ололт амжилт нь шашинтай зөрчилдөж байдаг тул соёлын өөрчлөлтүүдэд зөрчил дагуулдаг.

8. Дараах өгөгдлүүдээс зөрчилдөөний ангиллыг олно уу.

Өгөгдөл: 1-Шалтгаан, 2-Эрчим, 3-Хэлбэр, 4-Зохицуулах, 5-Цар хүрээ, 6-Хугацаа, 7-Илрэх байдал/

A. 1, 2, 3, 5, 6	B. 1, 3, 4, 5, 6	C. 1, 3, 4, 6, 7	D. 1, 2, 5, 6, 7
------------------	------------------	------------------	------------------

9. Дараах өгөгдлүүдээс аль нь албан ёсны хэм хэмжээнд хамаарах вэ?

Өгөгдөл: /1-Хууль, 2-Дүрэм, 3-Журам, 4-Дургүйцэх, 5-Нүд үзүүрлэх, 6-Торгох, 7-Баривчлах, 8-Тусгайлан олгосон эрх хасах/

- A. 1, 2, 3, 6, 7, 8      B. 1, 2, 3, 4, 7, 8      C. 1, 4, 5, 6, 7, 8      D. 1, 3, 5, 6, 7, 8

10. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.

..... нь мөнгөтэй, түүнийгээ зарцуулах сонирхолтой худалдан авагчид буюу хэрэглэгчид, тэдэнд бараагаа борлуулж ашиг олох сонирхолтой худалдаачид буюу үйлдвэрлэгчдийн хоорондын харилцан үйлчлэл юм.

- A. Эдийн засаг      B. Орон нутгийн эдийн засаг      C. Зах зээл      D. Үйлдвэрлэл

11. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.

..... гэдэг нь төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг орон нутгийн иргэдэд хүргэж байдаг, төсвөөс санхүүждэг байгууллага.

- A. Төрийн бус байгууллага      C. Төрийн байгууллага  
B. Аж ахуйн нэгж      D. Олон улсын байгууллага

12. Дараах графикийг анхааралтай ажиглаад асуултад хариулаарай.

Асуулт: Доорх хүснэгтэд байгаа өгөгдлүүдийг ашиглаж эрэлт, нийлүүлэлтийн харилцан хамаарлыг тооцоолон илүүдэл болон хомсдолыг олоорой.


Бодлого №1

Үнэ	Эрэлт	Нийлүүлэлт	Илүүдэл/Хомсдол
1500	.....	.....	.....

P- Үнэ

Q-тоо хэмжээ

График №1



- A. Эрэлт 20000, нийлүүлэлт 30000 болж 10000 ширхэг бүтээгдэхүүний хомсдол бий болно.  
 B. Эрэлт 30000, нийлүүлэлт, 20000 болж 10000 ширхэг бүтээгдэхүүний илүүдэл бий болно.  
 C. Эрэлт 30000, нийлүүлэлт, 20000 болж 10000 ширхэг бүтээгдэхүүний хомсдол бий болно.  
 D. Эрэлт 20000, нийлүүлэлт 30000 болж 10000 ширхэг бүтээгдэхүүний илүүдэл бий болно.

13. Борлуулалтын орлого, нийт зардал, үр ашиг, татвар нь дараах ойлголтуудын алинд нь хамаарах вэ?

- A. Бизнесийн зорилго  
B. Үйлдвэрлэлийн төлөвлөгөө  
C. Бизнесийн бүтэц, зохион байгуулалт  
D. Санхүүгийн тооцоо

#### **14. Орлогын тооцооны дутууг гүйцээж тооцоолоорой.**

Хураах ногоо	Авах хэмжээ	Борлуулах үнэ	Орлогын дүн
Төмс	10кг	700	b.....
Лууван	30кг	a.....	15000
Сонгино	50кг	300	c.....
Орлогын дүн			37000

- A. a-500, b-7000, c-15000      C. a-400, b-7000, c-15000  
B. a-500, b-17000, c-5000      D. a-400, b-17000, c-5000


**15.** Дараах графикийг анхааралтай ажиглаад, асуултад хариулаарай.

## P- ҮНЭ, Q-тод хэмжээ

Асуулт: Зах зээлийн тэнцвэрийн цэг болон үнэ, тоо хэмжээг олоорой.

## График №1

## /Зайрмагийн эрэлт, нийлүүлэлтийн муруй/



- A. Зах зээлийн тэнцвэрийн цэг-A1-ээс B2, үнэ-1500, тоо хэмжээ-20000
  - B. Зах зээлийн тэнцвэрийн цэг-B1-ээс A2, үнэ-750, тоо хэмжээ-35000
  - C. Зах зээлийн тэнцвэрийн цэг-E, үнэ-1250, тоо хэмжээ-25000
  - D. Зах зээлийн тэнцвэрийн цэг-E-ээс A1, B2руу, үнэ-1250-1500, тоо хэмжээ-25000

#### **16. Хүний эрхийг юугаар хязгаарладаг вэ?**

- A. Хуулиар  
B. Ёс заншлаар  
C. Ёс суртахууны хэм хэмжээгээр  
D. Эрх мэдлээр

17. Төр хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хууль тогтоомжоор баталгаажуулах талаар төрийн хүлээх үүрэг аль нь вэ?

18. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг боловсруулсан ажлын хэсгийн ахлагч хэн бэ?  
A. Жон Локк C. Ж. Руссо  
B. Э. Рузвельт D. Малала Юсуфзай

19. Хүний эрх нь төрөөс олгож буй “хишиг биш, харин төрж мэндлэхэд нь хамт заяадаг түүний төрөлх чанар юм. Энэхүү ойлголт нь аль зарчимтай утга нийцэж байна вэ?  
A. Салшгүй байх зарчим C. Хүний эрхэм зэргийг хүндэтгэх зарчим  
B. Түгээмэл байх зарчим D. Хуваагдашгүй байх зарчим

20. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пактад аль нь хамаarahгүй вэ?  
A. Хөдөлмөрлөх C. Сурч боловсрох эрх  
B. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх D. Эрүүл мэндээ хамгаалуулах

21. Тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргад, хуралдаанд оролцсон хүмүүсийн хэдэн хувийн санал авсан нэр дэвшигчийг сонгон, баталгаажуулдаг вэ?  
A. 50-аас дээш хувь C. 60-аас дээш хувь  
B. 70-аас дээш хувь D. 80-аас дээш хувь

22. Сум, дүүргийн засаг даргыг хэн томилдог вэ?  
A. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал C. Ерөнхий сайд  
B. Баг, хорооны засаг дарга D. Аймаг, нийслэлийн засаг дарга

23. Бүх шатны засаг дарга нар хэдэн жилийн хугацаатай томилогддог вэ?  
A. 3 жил B. 4 жил C. 5 жил D. 6 жил

24. Баг хорооны Иргэдийн Нийтийн Хурлын эрх үүрэгт аль нь хамаарах вэ?  
A. Засаг даргыг томилох ажлаас чөлөөлөх  
B. Тухайн орон нутгийн төсвийг хэлэлцэн батлах  
C. Зарим иргэдэд татварын хөнгөлөлт үзүүлэх  
D. Нийгмийн болон зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх

25. Өөрийн орон нутагтаа тулгамдаж байгаа асуудлыг иргэд өөрсдөө эсвэл тэдний төлөөлөл хэлэлцэж шийдвэрлэхийн давуу талд хамаарахыг олно уу.  
A. Эрх мэдлийг орон нутагт олгох нь улс орны хөгжлийн нэгэн чухал үзүүлэлт мөн.  
B. Монгол улсад засгийн бүх эрх, ард түмний мэдэлд байна.  
C. Орон нутгийн удирдлагыг бүрдүүлэхэд гол үүргийг иргэд гүйцэтгэж байгаа учраас орон нутгийн эрх мэдлийн эх үндэс иргэдэд байдаг байна.  
D. Орон нутгийн түвшинд бүх асуудлыг шийдвэрлэдэг болсноор иргэдэд хүрэх төрийн үйлчилгээ ойрхон болно.